

МОНГОЛ УЛСЫН МЭДҮҮЛЭГЧИД

Монгол улсын иргэд дамжин өнгөрөх виз мэдүүлэхийн тулд зорчих улсынхаа визийг зайлшгүй авсан байх ёстойг анхаарна уу. Бусад улсын иргэд <http://www.immi.gov.au/visitors/transit/no-visa.htm> -д орж зорчих улсынхаа визийг авалгүй дамжин өнгөрөх виз мэдүүлэх эрхтэй эсэхээ шалгавал зохино.

Австрали улсад 72 цагаас доош хугацаагаар байх зорчигчид дамжин өнгөрөх виз мэдүүлэх боломжтой. Зорчигч нь (i) Австралиар дамжин өөр улсад зорчих гэж буй эсвэл (ii) Австралиар дайран өнгөрч буй хөлөг онгоцны багийн гишүүн гэдэгийг тус тус батлан харуулах шаардлагатай.

Хэрэв зорчигч дамжин өнгөрөхдөө Австралид зааснаас урт хугацаагаар байх төлөвлөгөөтэй бол “Жуулчны Виз” мэт тохирох визийг мэдүүлэвэл зохино.

Жагсаалтыг хэрхэн ашиглах тухай

1. Виз мэдүүлэгийн маягт дээр гарын үсэг зурахаас өмнө энэ жагсаалтын дагуу мэдүүлэгт шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлсэн эсэхээ сайтар хянаарай.
2. Мэдүүлгийн маягтыг зөв бөглөн шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлсэн гэж үзвэл мэдүүлгийн маягт дээр гарын үсэг зурж он сар өдөрөө тэмдэглэх хэрэгтэй.
3. Та энэ жагсаалтыг бөглөн мэдүүлгийн маягт болон холбогдох бичиг баримтийн хамт хавсаргасан байна.

Бусад чухал мэдээлэл

Таны виз мэдүүлгийн хариуг мэдүүлэг өгөх үед ирүүлсэн мэдээлэл болон бичиг баримтыг үндэслэн шийдвэрлэх магадлалтайг анхаарвал зохино. Мөн мэдүүлэг боловсруулах явцад нэмэлт бичиг баримт шаардаж болзошгүй.

Анхаарвал зохих зүйлс:

- Гадаад паспортаас бусад бичиг баримтын эх хувийг ирүүлэхгүй байх;
- Монгол хэл дээрх бүх бичиг баримтыг баталгаат орчуулгаар англи хэлрүү хөрвүүлсэн байх.

МАЯГТ БОЛОН ХУРААМЖ	Бүрдүүлсэн материалаа сонгоно уу	Албаны тэмдэглэгээ
Мэдүүлэгийн маягт 876 http://www.immi.gov.au/allforms/pdf/876.pdf Англи хэлээр бөглөсөн байна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Дамжин өнгөрөх виз төлбөргүй байдаг	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ХУВИЙН БИЧИГ БАРИМТУУД		
Хүчинтэй гадаад паспорт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Паспортын хэмжээтэй зураг нэг хувь. Зургийг мэдүүлгийн маягтын нүүр хуудсанд хавсаргасан байна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

АЯЛАЛЫН БИЧИГ БАРИМТУУД		
Аялалын нотлох баримт. Тухайлбал нисэх билетийн хуулбар	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Зорчих улсад нэвтрэх зөвшөөрөл. Тухайлбал тэр улсын виз	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Виз мэдүүлэгч би:

- энэ жагсаалтын дагуу шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлж мэдүүлэгт багтаасан болно.

энэ жагсаалтад заасан, миний виз мэдүүлэгт шаардагдах бүх бичиг баримтыг бүрдүүлээгүй, түүнчлэн мэдүүлэгийн хариуг миний бүрдүүлсэн мэдээллийг үндэслэн шийдвэрлэх магадлалтайг ойлгож байна.

Мөн цагаачлалын албанаас нэмэлт бичиг баримт шаардвал холбогдох шуудангийн төлбөрийг би өөрөө хариуцах ёстойг ойлгож байна.

Виз мэдүүлэгч би:

цагаачлалын албатай и-мэйлээр холбогдохыг зөвшөөрч байна.

цагаачлалын албатай и-мэйлээр холбогдохыг зөвшөөрөхгүй байна, түүнчлэн бичиг баримтын эх хувийг Бээжин дэх цагаачлалын албанд хүргүүлэхтэй холбоотой нэмэлт хугацаа болон төлбөр шаардагдах магадлалтайг ойлгож байна.

Санамж: Хэрэв виз мэдүүлэгч 18 нас хүрээгүй бол түүний эцэг/эх эсвэл асран халамжлагч түүнийг төлөөлөн гарын үсэг зурна.

Виз мэдүүлэгчийн нэр:

Гарын үсэг:

Он сар өдөр:

.....

.....

...../...../.....

Албаны тэмдэглэгээ

Ажилтны нэр: